*Хавсралт хүснэгт 3.7*

## УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2024 ОНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

| № | *Шалгуур үзүүлэлт* | *Хэрэгжилт* | *Хувь* |
|---|---|---|---|
| **Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал** | | | |
| 1.1 | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | ✓ Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг сурталчилан таниулах зорилгоор эмнэлгийн төв хүлээлгийн танхим, үйлчлүүлэгч зорчих бүх цахилгаан шат, хурлын заалны коридор, тасаг нэгж бүрт ил тод байршуулсан. Эмнэлгийн www.shastinhospital.mn цахим хуудасны нүүр хуудасны "Бидний тухай" хэсэгт ил тод нээлттэй байршуулсан.<br>✓ Эрүүл мэндийн яамны удирдах зөвлөлд УГТЭ-ийн стратеги төлөвлөгөө танилцуулан, улсын хэмжээнд хэрэгжүүлэх бодлого хөтөлбөртийн үйл ажиллагааг тусган ажилласан.<br>✓ Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын алсын хараа, эрхэм зорилгыг ажилтан бүрт таниулан сурталчилж, шинэ ажилтны чиглүүлэх сургалтанд заалт бүрийг тайлбарлан таниулах сургалт хийгдсэн. | 100% |
| 1.2 | Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | ✓ Эмнэлгийн www.shastinhospital.mn цахим хуудасны толгой, хөл, хажуу хэсгүүдэд холбоо барих утасны дугаар, имэйл хаяг, фейсбүүк хуудасны холбоосыг байршуулсан.<br>✓ Иргэд үйлчлүүлэгчид эмнэлгийн танилцуулга, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйлчилгээ, ил тод байдал, шилэн данс, тушаал шийдвэр, ажлын байрны зар, мэдээ мэдээллийг шуурхай авах нөхцлийг бүрдүүлж, тогтмол шинэчилж хэвшсэн.<br>✓ Цаг үеийн мэдээ мэдээлэл, эмнэлгийн тусламж үйлчилгээний ололт амжилтыг иргэд олон нийтэд фэйсбүүк нийгмийн сүлжээгээр дамжуулан тогтмол хүргэж хэвшсэн. Нийгмийн сүлжээний хаяг: https://www.facebook.com/shastinhospital/ | 100% |
| 1.3 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | ✓ 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хяналт шалгалтын дагуу ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн ажлын тайланг ил тод нээлттэй мэдээллэсэн. | 100% |
| 1.4 | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | ✓ Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг гарган 2024 оны 1/756 тоот албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>✓ Худалдан авах ажиллагааны tender.gov.mn болон эмнэлгийн цахим хуудсанд 2024 оны байдлаар нийт 22 тендерийн 30 удаагийн зар болон үр дүнг тус тус нийтлэж ил тод байдлыг хангаж ажилласан.<br>- 2024 онд www.shilendans.gov.mn цахим хуудсанд төсөв гүйцэтгэлийн 74, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 24, бусад 62, нийт 163 мэдээллийг байршуулсан. Шилэн дансны | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | улирлын тайланг цахим хэлбэрээр илгээж биелэлтийн тайланг Эрүүл мэндийн яамны хяналт шинжилгээ дотоод аудитын газарт хүргүүлэн ажилласан.<br>- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдан тендерийн ерөнхий мэдээллийг давхардсан тоогоор 294 удаа, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр, нийт 1420 удаа мэдээллэж ажилласан.<br>✓ Эмнэлгийн цахим хуудсанд тусламж үйлчилгээтэй холбоотой тушаал журмыг үйлчилгээний цэсний тушаал журам, үйл ажиллагаа, хүний нөөц, худалдан авахтай холбоотой тушаал журмуудыг ил тод цэсний холбогдох цэснүүдэд, тус тус байршуулсан бөгөөд 2024 онд эмнэлгийн үйл ажиллагааны ил тод байдал, тушаал шийдвэр бүхий 265, хүний нөөцийн ил тод байдлын 79 тушаал, тендер, санхүүтэй холбоотой 160, нийт 504 тушаал байршуулсан.<br>✓ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоол Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай тогтоол, Эмнэлгийн даргын 2024 оны А/120 дугаар тушаалаар "Эмнэлгийн төлбөртэй жагсаалтыг шинэчлэн батлах тухай", төлбөртэй тусламж үйлчилгээний үнийн жишгийг эмнэлгийн цахим хуудас болон иргэдийн танхимын мэдээллийн самбарт байршуулсан. | |
| 1.5 | Хөгжлийн бодлого баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | ✓ 2024 оны байдлаар эмнэлгийн цахим хуудсанд шинээр баталсан бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний акт, тушаал шийдвэрүүд 209 байршсанаас цахим хуудасны ил тод цэсэнд төлбөрт үйлчилгээ, үнэлгээний хороо, ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг эмнэлгийн үйл ажиллагааны ил тод байдал, тушаал шийдвэр бүхий захирлын тушаал 102, хүний нөөцийн ил тод байдлын 25 тушаал, тендер, санхүүтэй холбоотой 53 тушаал тус тус байршсан. Мөн дээрх мэдээллийг долоо хоног тутмын хариуцлагатай ажилтны шуурхай хуралдаанд мэдээлж хэвшсэн.<br>✓ Эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд Эмнэлгийн захирлын 2022 оны А/303 дугаар тушаалаар баталсан "Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2022-2025 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг байршуулсан.<br>✓ Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Төрийн албан хаагчийн нийгмийн хамгааллын тайлан, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй иргэдэд ээлтэй орчин нөхцөл бүрдүүлсэн байдлын тайланг эмнэлгийн цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулсан. | 100% |
| 1.6 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | ✓ Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төсийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрүүд, Эрүүл мэндийн сайдын тушаал журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөн, тайлан мэдээг хугацаанд нь гарган холбогдох газарт хүргүүлж ажилласан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ✓ Эмнэлгийн цахим хуудасны ил тод байдал хэсэгт “Хуулийн төсөлд санал авах” холбоосыг ажиллуулж, parliament.mn дээр санал авч байгаа хуулийн төслүүд хэсэг рүү шилждэг байдлаар шийдэн ажиллуулж байна.<br>✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн заалтуудыг Хариуцлагатай ажилтны шуурхай хурал, эмч нарынярианд тогтмол сурталчилж, нийт 8 удаа танилцуулсан. | |
| 1.7 | Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар албаны цахим шуудангийн хаяг; | ✓ Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Албан тушаалын тодорхойлолтын маягтын дагуу тус эмнэлгийн нийт 191 ажлын байрны албан тушаалын тодорхойлолтуудын загварыг шинэчлэн Эмнэлгийн захирлын тушаалаар баталж, эмнэлгийн дотоод сүлжээ болон цахим хуудсанд байршуулсан.<br>✓ Албан тушаалтны эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаарыг нэгтгэн гаргаж өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэж хэвшсэн. | 100% |
| 1.8 | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | ✓ Эмнэлгийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллийг иргэд Засгийн Газрын Иргэд олон нийттэй харилцах төв, Эрүүл мэндийн яаманд хандах цахим хаяг, утасны дугаар зэрэг мэдээллийг тасаг нэгжүүдийн мэдээллийн самбарт байршуулсан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/50 дугаар тушаал, Эмнэлгийн захирлын 2022 оны “Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах шийдвэрлэх хяналт тавих журам“ А/138 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>✓ 2024 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар 410 иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Иргэдээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 335(80.7%) нь бичгээр, 62(15.1%) нь Засгийн газрын 11-11 төвийн утсаар, 8(1.9%) нь биеэр, 6 (1.4%) нь цахимаар, 4(0.9%) нь утсаар ирүүлснийг хүлээн авч ажлын 1-3 өдөрт 100% шийдвэрлэсэн.<br>✓ Эмнэлгээр үйлчлүүлэгч, тэдний ар гэрээс эмч мэргэжилтний харилцаа хандлага, мэргэжлийн ур чадвартай холбоотой 1071 талархал ирүүлсэнийг хамт олны хурал, эмнэлгийн цахим хуудас, эмнэлгийн дотоод сүлжээ, долоо хоног бүрийн Даваа, Мягмар гарагийн Хариуцлагатай ажилтны хурал, холбогдох тасаг нэгжид мэдээлж, эмнэлгийн болон Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд байршуулж, сурталчлан ажилласан.<br>✓ Засгийн газрын 11-11 төвд талархал 831, гомдол 32, санал хүсэлт нийт 82 ирснийг эмнэлгийн цахим хуудсанд байршуулсан. | 100% |
| 1.9 | Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | ✓ Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тоот тушаалын дагуу Стационари, Амбулатори, Оношилгоо шинжилгээ, Сэргээн засах, Яаралтай тусламж зэрэг 5 чиглэлийн статистик үзүүлэлт, мэдээ тайланг сар бүрийн хариуцлагатай ажилтны шуурхай хурал, эмч нарын ярианд танилцуулж, эмнэлгийн цахим хуудсанд ил тод байршуулж хэвшсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ✓ Мөн Эрүүл мэндийн сайдын 2014 оны 139 тоот Эх хүүхдийн эрүүл мэндийн тандалтын тушаалын дагуу Эхийн ноцтой хүндрэлийн 1 тохиолдол, 0-5 насны хүүхдийн эндэгдэл 3 тохиолдлыг ЭХЭМҮТ-д мэдээллэсэн.<br>✓ Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 тоот "Томуу, томуу төст өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай" тушаалын дагуу амбулаторийн мэдээг өдөр бүр, стационарын мэдээг 7 хоногт 1 удаа нэгтгэж fis.flu.mn хаягаар онлайнаар ХӨСҮТ рүү шивж оруулах ажил тогтворжсон.<br>✓ Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 тоот тушаалын дагуу Хүлээгдлийн мэдээг амбулатори, стационари, лаборатори, оношилгоо, шинжилгээний төрлөөр ангилан сар бүр гарган Эрүүл мэндийн яаманд мэдээллэсэн.<br>✓ Өдөр тутмын эмнэлгийн тусламж үйлчилгээний ачаалал, статистик тоон мэдээг дотоод сүлжээгээр тогтмол мэдээлж хэвшсэн. | |
| 1.10 | Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээнй хөтөлбөр; | 2024 онд олон нийтэд зориулсан 46 арга хэмжээг эмнэлгийн цахим хуудас болон нийгмийн сүлжээнд байршуулж, мэдээлсэн.<br>Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх сэдвээр ЭМЯ болонэмнэлгийн цахим хуудас, нийгмийн сүлжээнд нийт 332 удаагийн постер зөвлөгөө, 25 удаагийн видео зөвлөгөө, эмч зөвлөж байна ярилцлага 3 удаа байршуулж сурталчилан ажилласан. Төгсөлтийн дараах сургалттай холбоотой мэдээ мэдээллийг цаг тухай бүрт 8 удаа мэдээллэн ил тод байдлыг хангаан ажилласан.<br>Эмнэлгийн албан ёсны Фэйсбүүк хуудсанд Зурган мэдээлэл 129 удаа, видео мэдээлэл 42, богино хэмжээний үйл ажиллагааны видео мэдээлэл 8 удаа нийт 179 мэдээлэл бэлтгэн хүргэн 1 сая гаруй үзэлттэй байна. | 100% |
| | Хэсгийн дундаж хувь | | 100% |
| **Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод нээлттэй байдал** | | | |
| 2.1 | Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | ✓ 2024 онд 30 сул орон тооны зарыг www.zangia.mn-ээр 69 удаа зарлаж нийт хандалтын тоо 13,697, эмнэлгийн албан ёсны цахим хуудас www.shastinhospital.mn-нд 69 зарыг байршуулж, олон нийтийн нийгмийн сүлжээ Улсын гуравдугаар төв эмнэлэг фейсбүүк цахим хуудсанд 47 удаа байршуулж, хандалтын тоо 24,457, эмнэлгийн дотоод сүлжээгээр ажлын байрны зарыг 84 удаа байршуулан ил тод нээлттэй зарласан. | 100% |
| 2.2 | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | ✓ Эмнэлгийн захирлын 2021 оны А/257 дугаар тушаалаар "Шинэ ажилтан сонгон шалгаруулах журам"-ыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.<br>✓ "Шинэ ажилтан сонгон шалгаруулах журам" нь 8 бүлэг, 62 зүйлтэй, сонгон шалгаруулалтад баримтлах зарчим, үйл ажиллагааны дараалал, зохион байгуулалт, комиссын эрх, үүрэг, сонгон шалгаруулалтын дүнг нэгтгэх, ил тод нээлттэй мэдээллэх гэсэн заалтуудыг тусган мөрдөн ажилласан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ✓ Нээлттэй сонгон шалгаруулалтад 261 хүн материал ирүүлснээс 29 удаагийн сонгон шалгаруулалт, ярилцлагыг явуулсан. 2024 онд шинээр 170 хүнийг ажлын байраар хангасан. | |
| 2.3 | Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | ✓ 2024 онд албан хаагчийн ёс зүй харилцаа хандлагатай холбоотой 4 гомдол ирснээс үндэслэлтэй 2 гомдлыг Ёс зүйн салбар хорооны хурлаар авч хэлэлцэн шийдвэрлэсэн.<br>✓ Эмнэлгийн цахим хуудсанд эмнэлгийн захирлын 2024 оны А/222 дугаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн батлах тухай тушаал болон 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөөг байршуулан ажилласан.<br>✓ Тайлант онд эмч, сувилагч тусгай мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага ажлын байрны сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор сургалт -9 удаа, давхардсан тоогоор 671 эмч, сувилагч тусгай мэргэжилтэнд зохион байгуулсан.<br>✓ Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай /шинэ/ хуулийг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дэд хорооны цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулсан.<br>✓ Эмнэлгийн ёс зүйг эрхэмлэгч эмч, сувилагч, эмнэлгийн ажилтныг шалгаруулах үйл ажиллагааг 40 тасаг, төв, албадыг хамруулан 3 шаттайгаар зохион байгуулж, шалгарсан ажилчдад батламж олгож, зургийг хүндэтгэлийн самбараар алдаршуулж хэвшсэн.<br>✓ Эмнэлгийн захирлын 2024 оны А/01 дугаар тушаалаар эмнэлгийн нийт ажилтнуудын ажил мэргэжлийн хариуцлага, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эерэг хандлагыг түгээх, эмнэлгийн үйл ажиллагаанд нийт хамт олны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, ажлын гүйцэтгэл бүтээмжийг нэмэгдүүлж, чанартай, эрсдэл аюулгүй тусламж үйлчилгээг сэтгэл ханамжтай үзүүлэх зорилгоор "2024 оныг Эерэг хандлага, бүтээлч манлайлал"-ийн болгон зарлаж, тушаалыг эмнэлгийн цахим хуудсанд байршуулсан.<br>✓ 2024 оны зорилтот жилийн хүрээнд "Компаний засаглалын шинжилгээний хүрээлэнтэй хамтран "Эерэг хандлага" сэдэвт 6 цуврал сургалтыг эмнэлгийн нийт эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, дэмжин туслах албадын ажилчдад ажлын байран дээр 8 сэдвээр 14 удаа зохион байгуулсан. Тус сургалтад 1221 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>✓ Тус эмнэлэг нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/50 дугаар тушаал, Эмнэлгийн захирлын 2022 оны "Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах шийдвэрлэх хяналт тавих журам" А/138 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>✓ 2024 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар 410 иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Иргэдээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 335(80.7%) нь бичгээр, 62(15.1%) нь Засгийн газрын 11-11 төвийн утсаар, 8(1.9%) нь биеэр, 6 (1.4%) нь цахимаар, 4(0.9%) нь утсаар ирүүлснийг хүлээн авч ажлын 1-3 өдөрт 100% шийдвэрлэсэн.<br>✓ Эмнэлгээр үйлчлүүлэгч, тэдний ар гэрээс эмч мэргэжилтний харилцаа хандлага, мэргэжлийн ур чадвартай холбоотой 1071 талархал ирүүлсэнийг хамт олны хурал, эмнэлгийн цахим хуудас, эмнэлгийн дотоод сүлжээ, долоо хоног бүрийн Даваа, Мягмар гарагийн Хариуцлагатай ажилтны | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | хурал, холбогдох тасаг нэгжид мэдээлж, эмнэлгийн болон Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд байршуулж, сурталчлан ажилласан. | |
| 2.4 | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | ✓ Эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд Эмнэлгийн захирлын 2022 оны А/303 дугаар тушаалаар баталсан “Улсын гуравдугаар төв эмнэлгийн 2022-2025 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг байршуулсан.<br>✓ Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Төрийн албан хаагчийн нийгмийн хамгааллын тайлан, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй иргэдэд ээлтэй орчин нөхцөл бүрдүүлсэн байдлын тайланг эмнэлгийн цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулсан.<br>✓ 2024 онд шилжилт хөдөлгөөн 14.7 хувь буюу ажлаас гарсан 113, шинээр ажилд орсон 170 ажилтан байна. Оны эцсийн орон тооны гүйцэтгэл 98,3% буюу 797 ажилтан ажиллаж байна. Өмнөх онтой харьцуулахад 3,9% хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 100% |
| 2.5 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | ✓ 2024 онд хүний нөөцийн удирдлага мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, журам, сул ажлын байрны зар, сонгон шалгаруулалтын дүн мэдээ, үйл ажиллагааны тайлан мэдээллийг эмнэлгийн цахим хуудсанд тухай бүр байршуулсан.<br>✓ Эмнэлгийн хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлд хэрэгжүүлж буй хөгжлийн хөтөлбөр, нийгмийн хамгааллын бодлого, зорилтот арга хэмжээ, аяны удирдамж, төлөвлөгөө, тайланг цахим хуудсандаа тод байршуулсан.<br>✓ Эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн үнэлэмжийг өсгөх, цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2024 оны 01 дүгээр сараас эхлэн үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэн олгосон. Засгийн газрын 2024 оны 128 тогтоолоор баталсан доод жишгээс эрүүл мэндийн ажилтны цалин 27 хувиар, нийтлэг үйлчилгээний ажилтны цалин 14 хувиар нэмэгдсэн байна.<br>✓ 2024 онд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1-25 хувиар тооцож, нийт 808 хүнд нэмэгдэл олгож байна. | 100% |
| 2.6 | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам; | ✓ Засгийн газрын 2019 оны 05 дугаар, 395 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг хэрэгжүүлэхээр албан хаагчийн ажлын үр дүн гүйцэтгэлийн үнэлэх журмыг Эмнэлгийн захирлын 2022 оны А/97 дугаар тушаалаар батлаж, ажил мэргэжлээс шалтгаалан ялгаатай шалгуур үзүүлэлтээр улирал бүр дүгнэн ажилладаг.<br>✓ 2024 оны 4 улиралд давхардсан тоогоор 2,980 албан хаагчид ажлын үр дүнг үндэслэн 2,150,894,161 төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон.<br>✓ Нэгжийн менежерүүдийн удирдах ур чадвар, ажлын үр дүн, гүйцэтгэл хариуцлагын тогтолцоог сайжруулах, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор оношилгоо эмчилгээний тасаг нэгжийн 32 эрхлэгчтэй удирдлагын багийн гишүүд төлөвлөгөөт уулзалт хийн, шалгуурын дагуу менежрүүдийн ажлыг дүгнэн, холбогдох мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 100% |
| | Хэсгийн дундаж хувь | | 100% |

| Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх | | | |
|---|---|---|---|
| 3.1 | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | ✓ Эрүүл мэндийн сайдын 2024 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 1а/3292 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу тус эмнэлэг нь Эрүүл мэндийн яаманд 2025 оны төсвийн төсөл, 2026, 2027 оны төсвийн төсөөлөл, 2024 оны санхүүгийн тайлан өгөх хуваарийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгсөн.<br>✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар төсөвт тодотгол хийлгэхээр 2024 онд 1 удаа хэлэлцүүлж, батлуулсан. | 100% |
| 3.2 | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | ✓ Төсвийн гүйцэтгэлийг нарийн хянаж төсвийн дагуу хэтрэлтгүй биелүүлж сар бүр ЭМЯ-ны төрийн санд мэдээ тайлан өгч ажилласан. Улирал бүр санхүүгийн тайлан гаргаж удирдлага, холбогдох харьяа байгууллагуудад тайлагнахаас гадна шилэн дансанд хуулийн дагуу www.shilendans.mn цахим хуудсанд 14 удаа мэдээлэл тайланг байршуулан ажиллаж байна.<br>✓ Удирдлагын зөвлөлийн хуралд санхүү, эрүүл мэндийн даатгалын төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал тутам хэлэлцүүлж, шаардлагатай зөвлөмжийг өгч, шуурхай арга хэмжээ авч ажилладаг. | 100% |
| 3.3 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хяналт шалгалтын дагуу ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр Эмнэлгийн захирлын 2024 оны А/67 дугаар тушаалаар төлөвлөгөө гарган биелэлтийг 100% ханган ажиллаж, тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Тайланг шилэн дансанд ил тод байршуулсан.<br>2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдэж байна. | 100% |
| 3.4 | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээний норм нормативыг шинэчлэн эмнэлгийн захирлын 2024 оны А/111 дүгээр тушаалаар батлан мөрдөн ажилласан. Эмнэлгийн цахим хуудасны ил тод цэсэнд байршуулсан.<br>✓ Төлбөр, хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээг Эмнэлгийн захирлын 2024 оны Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх жагсаалт, журам батлах тухай А/120 дугаар тушаалыг цахим хуудсанд байршуулсан.<br>✓ Үйлчилгээний төлбөрийг эмнэлгийн нэг давхарт байрлах Төрийн банкны салбар кассанд тушаалгаж хэвшсэн. | 100% |
| 3.5 | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | ✓ Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт шилэн дансанд сар бүр "Төсөв/ гүйцэтгэл" хэсэгт эдийн засгийн ангилалаар нь тайлагнаж хэвшсэн.<br>✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай Эмнэлгийн захирлын 2024 оны А/110 дугаар тушаалаар сахилга хариуцлагыг бүх түвшинд өндөржүүлэн, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг 100% ханган, Эмнэлгийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>✓ Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг ил тод мэдээллэсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, албан хаагчдад хууль сурталчилах зорилгоор 7 хоног бүрийн даваа гарагт хариуцлагатай ажилтны шуурхай хуралд хуулийн заалт бүрийг цувралаар хүргэж байна. | |
| 3.6 | Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг; | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг 12 удаа нийт 133 мэдээлэл оруулсан байна. | 100% |
| 3.7 | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу тухайн жилийн төсөв, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг сар бүрийн 10-ны өдрийн дотор, 6.4.4 дэх заалтыг үндэслэн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын зардлын гүйцэтгэлийн мэдээг сар бүр буюу нийт 12 удаа www.tender.gov.mn, www.shastinhospital.mn цахим хуудсуудын Санхүүгийн ил тод байдал хэсэгт байршуулж, нийтэд мэдээлэх үйл ажиллагааг тогтмолжуулсан.<br>Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр, нийт 1035 удаа мэдээллэж ажилласан. | 100% |
| 3.8 | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Шилэн данс цахим хуудасны Бусад хэсэгт сар бүр 7 баганаар жагсаалт оруулж, нийт 73 мэдээлэл болон бусад хавсралт файлыг оруулж ажилласан.<br>Шилэн дансанд 437 гэрээг ил тод нээлттэй мэдээлсэн. | 100% |
| 3.9 | Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | ✓ 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хяналт шалгалтын дагуу ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр Эмнэлгийн захирлын 2024 оны А/67 дугаар тушаалаар төлөвлөгөө гарган биелэлтийг 100% ханган ажилласан.<br>✓ Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилтийн талаар Удирдлагын зөвлөлийн хурлаар улирал тутам хэлэлцэж, тайланг нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлж хэвшсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 3.10 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | ✓ 2024 онд www.shilendans.gov.mn цахим хуудсанд хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 24, бусад 62, нийт 163 мэдээллийг байршуулсан. Шилэн дансны улирлын тайланг цахим хэлбэрээр илгээж биелэлтийн тайланг Эрүүл мэндийн яамны хяналт шинжилгээ дотоод аудитын газарт хүргүүлэн ажилласан.<br>✓ Худалдан авах ажиллагааны tender.gov.mn болон эмнэлгийн цахим хуудсанд 2024 оны байдлаар нийт 22 тендерийн 30 удаагийн зар болон үр дүнг тус тус нийтлэж ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% |
| 3.11 | Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт; | Аудитын 2023 оны зөвлөмжөөр худалдан авалтын төлөвлөгөөний дагуу худалдан авалтын хийн ажиллах тухай зөвлөмжийг ирүүлсний дагуу 2024 оны худалдан авах ажиллагааг 100% төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. | 100% |
| 3.12 | Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу худалдан авалтыг tender.gov.mn цахим хэлбэрээр зохион байгуулан ажилласан.<br>2024 онд худалдан авах ажиллагаатай холбоотой тендерт оролцогчдоос санал хүсэлт ирүүлсний дагуу 4 тодруулгыг tender.gov.mn-д ил тод нээлттэй байдлаар байршуулсан. | 100% |
| 3.13 | Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | ✓ Люксембургийн MON007 төслийн бүх гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланг шилэн дансанд тухай бүрд нь байршуулсан.<br>✓ MON007 төслийн гүйцэтгэл, үр дүн, үйл ажиллагаанд Олон улсын аудитын баг болон Үндэсний аудитын газрын хяналт шалгалт ажиллаж, шалгуур тус бүрээр дүгнэсэн. | 100% |
| 3.14 | Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | 2024 онд эмнэлгийн захиалгаар судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй. | - |
| 3.15 | Хууль тогтоомжид заасан бусад; | Хууль тогтоомжид заасан үүргийг бүрэн хэрэгжүүлж ажилласан. | 100% |
| Хэсгийн дундаж хувь: | | | 100% |
| **Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээлэл** | | | |

<table>
<tr>
<td>4.1</td>
<td>Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;</td>
<td>
✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээний норм нормативыг шинэчлэн эмнэлгийн захирлын 2024 оны А/111 дүгээр тушаалаар батлан мөрдөн ажилласан. Эмнэлгийн цахим хуудасны ил тод цэсэнд байршуулсан.<br>
✓ Төлбөр, хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээг Эмнэлгийн захирлын 2024 оны Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх жагсаалт, журам батлах тухай А/120 дугаар тушаалыг цахим хуудсанд байршуулсан.<br>
✓ Үйлчилгээний төлбөрийг эмнэлгийн нэг давхарт байрлах Төрийн банкны салбар кассанд тушаалгаж хэвшсэн.<br>
✓ 2024 онд төрөлжсөн мэргэшлийн оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн 6 зааврыг шинээр боловсруулан Эмнэлгийн захирлын А/113, 115, 116, 17, 118, 119 дүгээр тушаалаар батлан, хэрэгжилтийг ханган ажилласан.<br>
✓ Тус эмнэлэг нь 2024 онд Төрөлжсөн мэргэжлийн амбулаторийн 32 кабинетаар 223,217 үзлэг тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Амбулаторийн тусламж үйлчилгээ нь өмнөх оны мөн үеэс 14,3 хувь, оношилгооны үзүүлэлт 1,4 хувиар тус тус буурсан нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 06 дугаар тогтоолоор амбулаторийн тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлэхтэй холбоотой байна.<br>
✓ Иргэд үйлчлүүлэгчдийн шинжилгээний хариу eMongolia системд шууд бүртгэгдэж байгаа бөгөөд гар утсанд мессеж хэлбэрээр мэдэгдэл очиж байна. Иргэн өөрөө хэвлэхийг хүссэн үедээ өөртөө үйлчлэх КИОСК машиныг ашиглан хэвлэж байгаа бөгөөд 2024 оны байдлаар 24,481 хүний 49.7 мянган хуудас шинжилгээний хариуг хэвлэсэн байна.<br>
✓ Амбулаторийн эмчийн анхан үзлэгийн цагийг төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn), цаг захиалгаар нэгдсэн дуудлага 1800-0119, эмнэлгийн цаг захиалгын 7704-6666, цахим бүртгэл гэсэн 4 өөр сувгаар захиалж иргэд хүлээгдэл, чирэгдэлгүй үзүүлэх нөхцөл байдлыг хангаж ажиллаж байна. 2024 онд:<br>
o Цаг захиалгын нэгдсэн дуудлага 1800-0119 дугаараар 21,462 захиалга<br>
o Эмнэлгийн өөрийн цаг захиалын 7704-6666 дугаарт 36,088 цаг захиалга<br>
o eMongolia системд 10,856 цаг захиалга.<br>
o Эмнэлгийн цахим бүртгэлээр 165,982 цаг захиалга хийгдсэн байна.<br>
✓ Дээрх бүртгэл нь зөвхөн эмчийн анхан үзлэгийн цаг бөгөөд eMongolia, 1800-0119, 7704-6666 зэргээр цаг захиалсан тохиолдолд 60-80 хувь нь товлосон цагтаа үзүүлдэггүй цуцалдаг тул 2024 онд 77046666 дугаарын дотуур утсаар ашиглалтад оруулан товлосон цагаас 1 өдрийн өмнө залган сануулах үйлчилгээг нэвтрүүлэн 3,273 хүн рүү залгаж сануулах эсвэл цуцлах үйлчилгээг үзүүлэн хүлээгдэл чирэгдлийг бууруулан ажилласан.<br>
✓ 2024 онд үйлчлүүлэгч хөнгөлттэй ба хөнгөлтгүй эмийн жорыг цахимаар авдаг сервис шинээр хөгжүүлсэн. Төрийн үйлчилгээний eMongolia системд цахим жор илгээгддэг болж иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг улам бүр ойртуулсаар байна.
</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, зааврын хэрэгжилтийг тасралтгүй сайжруулах, эмч мэргэжилтний үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах, ЭМД-ийн сангаас тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжих үйл ажиллагааг хасагдал, хоцрогдол, алдаа дутагдалгүй ажиллах зорилгоор Эмнэлгийн захирлын 2021 оны А/262 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн даатгалын дотоод хяналтын нэгж"-ийг 2 их эмчийн бүрэлдхүүнтэй байгуулан тусламж үйлчилгээний чанарт дотоод хяналт тавьж ажиллаж байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний нийт 20 тасгийн 26880, нас баралтын 360, нийт 27240 өвчний түүхэнд эмнэлгийн анхан шатны бичиг баримтын хөтлөлт, эмчилгээ оношилгоо, эмнэлзүйн удирдамж, эмнэлгийн технологийн мөрдөлтийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, ЭМД-ын хяналтын нарийвчилсан шалгуураар үнэлэхэд хэрэгжилт 87,8% байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс (84,6%) 3.2% өссөн үзүүлэлттэй байна. Үнэлгээ хийх явцад өвчний түүхийн 3323 буюу 12.2%-д тохиолдол илэрснийг 98% засуулж, дутагдлыг арилгуулах арга хэмжээг тухай бүрт нь авч хэрэгжүүлж ажилласан. | |
| 4.2 | Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа; | ✓ Тус эмнэлэг нь Нийслэлийн Баянгол дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт Ард-Аюушийн гудамж 1а хаягт байрлан, 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Эрүүл мэндийн яамнаас олгосон ЭУ-02-23/3002 дугаартай "Төв эмнэлгийн тусламж үйлчилгээний тусгай зөвшөөрөл"-ийн дагуу төрөлжсөн төв эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.<br>✓ Улсын бүртгэлийн дугаар 9070001140, регистрийн дугаар 9077154.<br>✓ Магадлан итгэмжлэлийн хугацааг 2027 оны 03 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл сунгуулсан.<br>✓ Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлтийг license.mn зөвшөөрлийн цахим системд хуулийн хугацаанд нь материалыг бүрдүүлэн 5 жилээр буюу 2029 оны 12 сарын 30-ны өдрийг хүртэл сунгуулсан. | 100% |
| Хэсгийн дундаж хувь: | | | 100% |
| **Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал** | | | |
| 5.1 | Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | ✓ Эмнэлгийн цахим хуудасны Мэдээ цонхны "Хуулийн төсөлд санал авах" цэсийг байршуулан https://lawforum.parliament.mn/drafts цахим хуудастай холбон холбогдох саналыг авч ажилласан.<br>✓ Эрүүл мэндийн сайдын 2022 оны 50 дугаар тушаалаар "Иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах шийдвэрлэх хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг ханган, Эмнэлгийн захирлын 2022 оны "Өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам" А/138 дугаар тушаал батлан, хэрэгжилтийг ханган ажилласан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ✓ Иргэдийн санал хүсэлтийг тус эмнэлгийн www.shastinhospital.mn цахим хуудас, иргэдтэй харьцах 7004-6666 дугаар бүхий лавлах утас болон Иргэдийн танхимаар хүлээн авч, тайланг цахим хуудсанд байршуулж хэвшсэн.<br>✓ Засгийн газрын 11-11 төвөөр иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг ажлын 3-5 хоногийн дотор шийдвэрлэн, тайланг Эрүүл мэндийн яаманд хүргүүлэн ажилласан.<br>✓ ЭМЯ-нд өргөдөл, гомдол, санал шийдвэрлэлтийн мэдээг сар бүр тогтмол хүргүүлж ажилласан. | |
| 5.2 | Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | 2024 оны байдлаар эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн гэрчилгээ байхгүй. | - |
| 5.3 | Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | ✓ Зүрх судасны үндэсний төвийн барилга байгууламжтай холбоотой газрын зөвшөөрөл 5 албан бичгийг илгээсэн. | 100% |
| 5.4 | Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Улсын гуравдугаар төв эмнэлэг нь өөрийн эзэмшлийн 5,7589 га газрыг эзэмшдэг Улсын бүртгэлийн Э-2205001219 тоот гэрчилгээтэй. | 100% |
| 5.5 | Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | ✓ Эмнэлгийн нэр, хаяг, тусламж үйлчилгээний чиглэл, ажиллах цагийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээг www.shastinhospital.mn эмнэлгийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан.<br>✓ 2024 онд тус эмнэлэг улсын нэгдсэн төсөвт Хүн амын орлогын албан татвараар 2,329,438,812.83 төгрөгийг төвлөрүүлсэн.<br>✓ 2024 оны төсвийн орлогийн гүйцэтгэл 93,4%, зарлага 89,5%-тай ажилласан. | 100% |
| 5.6 | Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын ЭЦЭГ /ЭХ/-ИЙН нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах | ✓ 2020 оноос эхлэн Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т зааснаар тус эмнэлэгт Төлөөлөн удирдах зөвлөлтэйгээр ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүд нь Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан 9 гишүүнтэй, сарын цалинд тус бүр 630,000 төгрөг олгодог.<br>✓ Өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүнээр Д.Баярболд, М.Нармандах, Н.Уранцэцэг, эмнэлгийн хамт олныг төлөөлөх гишүүнээр Ц.Дамдинсүрэн, Ж.Өлзийтхүү, Ч.Баасанжав, олон нийтийг төлөөлөх гишүүнээр С.Тойвгоо, Н.Баясгалан, Б.Өнөрбилэг нар ажиллаж байна.<br>✓ 2020.02.22-ны өдөр Эмнэлгийн захирлын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулах зарыг эмнэлгийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэж, сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж, сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ТУЗ-ийн 2020 оны 04 дүгээр тогтоолоор тус эмнэлгийн даргаар ажиллаж байсан Ц.Төмөр-Очирыг Эмнэлгийн захирлаар томилогдон ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | ✓ Гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх заалтын дагуу тус эмнэлгийн Удирдлагын зөвлөл 9 гишүүнтэй. Үүнд Эмнэлгийн захирал, Эмнэлүй эрхэлсэн дэд захирал, Эрдэм шинжилгээ сургалт эрхэлсэн дэд захирал, Төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал, Сувилахуй эрхэлсэн дэд захирал, Захиргаа хүний нөөцийн албаны дарга, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга, Эрүүл мэндийн эдийн засаг төлөвлөлтийн албаны дарга, Санхүү бүртгэлийн албаны дарга, Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга нар ажиллаж байна. | |
| 5.7 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Актласан хөрөнгө байхгүй. | 100% |
| 5.8 | Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | МХЕГ-ын тэргүүн дэд даргын батласан 2022 оны 02/10 дугаартай удирдамжийн хүрээнд Эмнэлзүйн лавлагаа лабораторийн химийн бодис хадгалах өрөөнд 2022оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хяналт шалгалт хийж химийн болон хортой бодисууд нь хаалттай системтэй бүрэн автомат анализатороор хийгддэг, ямар нэг шингэн хог хаягдал гардаггүй, хүн ба мал амьтны эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөгүй, хоргүй гэсэн Улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг 2022 оны 02-06-338/1062 дугаар албан бичгээр ирүүлсэн. | 100% |
| 5.9 | Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | Эмнэлгийн үндсэн барилга 1985 онд ашиглалтад орсон. Эмнэлгийн өргөтгөлийн барилга барилгын норм дүрмийн дагуу баригдаж, 2012 онд улсын комисс хүлээн авч ашиглалтанд оруулсан. | 100% |
| 5.10 | Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ; | Үйл ажиллагаа хамаарахгүй. | - |
| 5.11 | Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | ✓ Цахим хуудасны "Статистик үзүүлэлт" цэс дотор сар бүр эмнэлгийн тусламж үйлчилгээний дэлгэрэнгүй статистик мэдээллийг иргэдэд нээлттэй танилцуулж хэвшсэн. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний "Статистик 2010-2020" оны 10 жилийн үзүүлэлтийг нэгтгэн дүгнэж байршуулсан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ✓ Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой эрүүл мэндийн зөвлөгөөний 9, АТГ-ийн 9 видео контент, эмнэлгийн статистик мэдээ мэдээллийг 40 удаа, 2024 оны байдлаар эмнэлгийн цахим хуудсанд нийт 467 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан. | |
| 5.12 | Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | Гадаад хамтын ажиллагааны хүрээнд гадаадын зочин профессорын багуудтай хамтарсан ажлын байрны мэс засал сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 11 улсын 13 байгууллагын 6 чиглэлийн зочин профессорын багийн 57 мэргэжилтэнг хүлээн авч хамтарсан эмнэлзүйн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.<br>Хамтарсан багаар Монгол улсад хараахан бие даан хийх боломжгүй нарийн төвөгтэй, өндөр ур чадвар шаардсан нийт 242 мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлснээс, насанд хүрсэн 159, хүүхдийн 83 тохиолдолд мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлсэн.<br>Гадаад зочин профессорын багтай хамтарсан мэс заслын тоо өмнөх оны мөн үеэс 3 дахин нэмэгдсэн.<br>Гадаад багтай хамтарсан мэс заслын тусламжаар нийт 3,188,222,340 төгрөгийн өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээг эх орондоо эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр хийж гүйцэтгэн, эрүүл мэндийн эдийн засгийн гадаад руу чиглэсэн урсгалыг бууруулж ажилласан. Зочин профессорын багтай хамтарсан эмнэлзүйн үйл ажисллагаагаар Эрүүл мэндийн сайдын А/273 дугаар тушаалын жагсаалтын А1,2, В6-10 дугаарт багтсан нийт 6 төрлийн бүлэг өвчний оношилгоо эмчилгээний технологийг нутагшуулах чиглэлээр эмч эмнэлгийн мэргэжилтнээ чадавхижуулж ажилласан. | 100% |
| 5.13 | Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл; | ✓ Мөн www.shastinhospital.mn цахим хуудасны Үйлчилгээ цэсэнд Эрүүл мэндийн даатгал цэсийг үүсгэн, өндөр өртөгт тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөр, хамтын төлбөр, эрүүл мэндийн даатгалын талаарх дэлгэрэнгүй мэдээллүүдийг байршуулж, мэдээллээр тогтмол хангаж ажилласан.<br>✓ Эмнэлгийн цахим хуудсанд eMongolia цахим системээр дамжуулан эмчийн үзлэгийн цаг захиалах, цуцлах, шинжилгээний хариу автоматаар илгээх мэдээллийг байршуулсан бөгөөд 2024 онд 14625 иргэн цаг захиалга авсан байна. | 100% |
| Хэсгийн дундаж хувь: | | | 100% |
| Хэрэгжилтийн дундаж хувь: | | | 100% |

ХЯНАСАН:
ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ, АНАГААХ УХААНЫ ДОКТОР Ц.ТӨМӨР-ОЧИР

НЭГТГЭСЭН: ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА Б.АЛЬГИРМАА

УЛААНБААТАР ХОТ П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ ТБАГУТҮГ ХТ00256 9077154